

Танилцуулга

Таван толгойн ордыг хөгжүүлэх төслийн талаар хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах тухай

Улсын Их Хурлын 2010 оны “Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 39 дүгээр тогтоол, 2014 оны “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 34 дүгээр тогтоол дагуу Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдөр “Таван Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 тоот тогтоолыг гаргасан билээ.

Улсын Их Хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолоор “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Таван толгойн ордын талаар Улсын Их Хурлаас баталсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд Таван толгойн орд газраас олборлож байгаа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулан, нэмүү өртөг шингээж, экспортын нэг цонхны бодлогын хүрээнд олон улсын зах зээлд борлуулах, уг зорилгоор орд газрыг иж бүрэн хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлыг эдийн засгийн үр ашигтай, улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байх хувилбараар, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог хангах зарчмаар цогцоор нь шийдвэрлэх”-ийг Засгийн газарт даалгасан.

Уг тогтоолын дагуу 2014 оны 9 дүгээр сард тухайн үеийн Ерөнхий сайд Н.Алтанхуяг тэргүүтэй Засгийн газраас өмнө нь уг ордыг сонирхож байсан гадаадын хөрөнгө оруулагчдын хүрээнд олон улсын үралдаант шалгаруулалт зарласан юм. Харин уг үралдаант шалгаруулалтыг дүгнэх, шалгарсан хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх ажлыг одоогийн Засгийн газар буюу Ерөнхий сайд Ч.Сайханбилэгийн захирамжаар байгуулсан ажлын хэсгээс гүйцэтгэсэн.

Тус ажлын хэсгийг томоохон төслийг хариуцсан ажиллах чиг үүрэг бүхий Монгол Улсын сайдаар ахлуулсан. Уг албан тушаалыг бий болгохдоо мега төслийн ярвигтай байдал, түүнд салбар хоорондын олон асуудлыг шийдэх хэрэгтэй болдог болон салбар хариуцсан сайдуудын ажлын уялдааг хангах, төр засгийн зүгээс мега төслийн асуудлыг хариуцсан эзэнтэй болгож, хариуцлага, үйл ажиллагааны нэгдсэн байлдыг хангах үүднээс том төсөл хариуцсан Монгол Улсын сайдын албан тушаал бий болгосон гэж ойлгож байгаа.

Миний бие энэ албан тушаалын ач холбогдлыг ойлгож, мэдлэг үр чадвараа дайчлан, Тавантолгой төслийг урагшлуулахын төлөө ажилласан болно. Ажлын хэсэгт багтаж надад итгэж, нүсэр ажлынхаа хажуугаар санал бодлоо хэлж ажлын хэсгийн ажлыг чиглэл, зөвлөлөгөөр хангаж байсан Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид, Зам тээврийн сайд Н.Төмөрхүү болон бусад сайд, Засгийн газрын гишүүдэд талархаж байна.

Төсөл ярвигтай, олон сонирхлын огтлолцолтой, улс төр, нийгмийн анхаарлыг татсан асуудал юм. Иймээс ажлын хэсгийн зүгээс үйл ажиллагаагаа ил тод байлгах зарчмыг удирдлага болгон ажилласан. Ил тод байх зарчмын хүрээнд ажлын хэсэг болон энэ төслийн хэлэлцээрт оролцоотой бүхий бүхий л төрийн байгууллагууд болон улс төрчид, нийгмийн идэвхтэй хэсэгт холбогдох мэдээллийг тухай бүр өгөх ажил багтаж байгаа.

Тиймээс ажлын хэсгийн зүгээс “megaproject.mn” веб сайтыг ажиллуулж, сэтгүүлчидтэй уулзалт ярилцлага хийж тэдэнд мэргэжлийн түвшинд мэдээлэл өгч ажиллахыг эрмэлзсэн.

Нөгөөтэйгүүр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл дээр гарч байгаа үзэл бодлуудыг мониторинг хийж, хэрэгтэй саналуудыг нь Ажлын хэсгийн ажилд тусган ажиллах зарчмыг баримталж ажилласан.

Түүнчлэн, ил тод байх зарчимд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон янз бүрийн мэргэжлийн болон салбарын мэргэжилтнүүдийн оролцоог хангаж, эрх хэмжээнд хутгалдахгүй байх асуудал ч багтаж байгаа. Тодруулбал, ажлын хэсгийн бүрэлдэхүүний дийлэнх хэсгийг улс төрийн албан тушаалтнууд бүрдүүлж байсан тул дэд ажлын хэсгийг мэргэжлийн хүмүүсийн түлхүү оролцоотойгоор байгуулж ажиллуулсан бөгөөд хоёр ажлын хэсгийн чиг үүргийг зохистой байдлаар хуваарилан ажилласан.

Ажлын хэсгийн шалгаруулалтаар Энержи Ресурс Корпораци, Шенхуа, Сумитомо буюу монгол, хятад, япон гэсэн 3 улсын хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдсэн консорциум 2014 оны сүүлчээр шалгарсан бөгөөд албан ёсны хэлэлцээг 2015 оны эхний долоо хоногоос эхлүүлж, түүнээс хойш 3 сарын дараа нэгдсэн тохиролцоонд хүрч чадлаа.

Аливаа том төслийн үр дүн нь хэлэлцээнээс ихээхэн хамаардаг. Энэ нь талууд харилцан ашигтай байх стратегийг баримтлан зөрөлдөөнтэй байсан байр сууриа нэгтгэж чадсан эсэх, зөвшилцлийг хэр хэмжээнд бий болгосноос хамаарна гэсэн үг. Хэлэлцээрийг 3-4 шатлалтайгаар явуулж, талууд нийтдээ 350 орчим асуудлаар байр сууриа нэгтгээд байна.

Эдгээр нь өнөөдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байгаа Хөрөнгө оруулалтын тухай гэрээ, “Ухаахудаг-Гашуунсүхайт чиглэлд төмөр замын суурь бүтэц барих төсөл”-ийн барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ (цаашид “төмөр замын концессын гэрээ” гэх), Хамтын ажиллагааны тухай гэрээ гэсэн 3 үндсэн гэрээнд туссан байгаа болно.

Ажлын хэсгийн болон хөрөнгө оруулагчдын хооронд хийсэн хэлэлцээрийн үр дүнг Засгийн газрын 268 дугаар тогтоолд заасан үндсэн шалгуурыг хэрхэн хангаж байгаагаар нь үнэлэх нь зүйтэй байх.

Нэг. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын заалтууд хэрхэн хангагдсан талаар:

Цаг хугацааны хувьд энэхүү хэлэлцээр хийхэд Засгийн газрын хувьд ч, хөрөнгө оруулагчдын хувьд ч таагүй байгаа нүүрсний салбарын суурь хүчин зүйл нөлөөлж байсан ч Таван толгойн орд газраас олборлож байгаа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулан, нэмүү өртөг шингээж, экспортын нэг цонхны бодлогын хүрээнд олон улсын зах зээлд борлуулах, уг зорилгоор орд газрыг иж бүрэн хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн асуудлыг эдийн засгийн үр ашигтай, улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байх хувилбараар, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог хангах зарчмаар цогцоор нь шийдвэрлэх гэсэн Улсын Их Хурал, Засгийн газрын зорилгыг хангах талаар хөрөнгө оруулагчидтай дараах байдлаар тохирсон болно. Тодруулбал, Засгийн газрын 268 дугаар тогтоолд заасан үндсэн 7 нөхцөл, шаардлага, зарчмыг дараах байдлаар хангалаа. Үүнд:

1. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн “а”-д “Төрийн өмчит “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн эзэмшилд байгаа Таван толгойн ордын ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулагчийн мэдэлд шилжүүлэхгүйгээр “Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээ”-ний хүрээнд бүрэн ашиглуулах”-аар заасан.

Төслийн хугацаанд Эрдэнэс Таван толгой ХК-ийн эзэмшилд буюу төрийн өмчид байгаа ашигт малтмалын ямар ч тусгай зөвшөөрөл хөрөнгө оруулагчдын өмчлөлд шилжихгүй, Эрдэнэс Таван толгой ХК-ийн өмчлөлд байгаа Баруун болон Зүүн цанхийн тусгай зөвшөөрлүүд төрийн өмчид хэвээр байна;

2. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн “б”-д “Хөрөнгө оруулагч нь Баруун болон Зүүн Цанхийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайд нүүрс олборлох, тэдгээр талбайд нэмэлт хайгуул хийж нөөцийг нэмэгдүүлэх”-ээр заасан.

Хөрөнгө оруулагч нь Таван толгойн нүүрсний ордын Баруун болон Зүүн Цанхийн хэсэгт нүүрс олборлох үйл ажиллагааг өөрийн зардлаар явуулах бөгөөд эдгээрээс бусад Эрдэнэс Таван Толгой ХК-ийн эзэмшилд байгаа бусад 4 лицензийн талбайд үйл ажиллагаа явуулах эрх Эрдэнэс Таван Толгой ХК-д хадгалагдана.

Төслийн хугацаанд Хөрөнгө оруулагч нь Баруун болон Зүүн Цанхийн хэсэгт нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх нэмэлт хайгуулыг өөрийн зардлаар хийх үүрэг хүлээж байгаа бөгөөд нэмж тогтоосон нөөцийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болох Эрдэнэс Таван толгойн нэр дээр бүртгэх юм. Хөрөнгө оруулагчдын зүгээс анх нэмэлт хайгуулын зардлыг Эрдэнэс Таван толгой ХК-иас нөхөн төлүүлэх санал ирүүлж байсан энэ асуудлыг хэлэлцээрийн явцад нөхөж төлөхгүй байхаар тохирч чадсан тул энэ асуудлаар төрийн зүгээс ямар нэг зардал гарахгүй;

3. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн “в”-д “Хөрөнгө оруулагчаар сонгогдон ажиллах эхний 2,5 жилийн хугацаанд багтаан Таван толгойн бүс нутагт 30.0 сая тонноос багагүй нүүрсийг баяжуулах хүчин чадлыг бий болгох, үйлдвэрлэсэн баяжмалыг 2-оос доошгүй орны зах зээлд нийлүүлэх”-ээр заасан.

Хөрөнгө оруулагч нь төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 2,5 жилийн хугацаанд өөрийн хөрөнгө оруулалтаар жилд 30 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадлыг одоо ажиллаж байгаа 15 сая тонн нүүрс баяжуулах үйлдвэрээ өргөтгөх замаар бий болгох бөгөөд Баруун болон Зүүн Цанхийн хэсэгт нүүрс олборлох уул уурхайн хүчин чадлыг ч өөрийн хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлнэ.

Өөрөөр хэлбэл, жил бүр 30 сая тонн нүүрс олборлон боловсруулж нэмүү өртөг шингээх уул уурхайн бүтээн байгуулалт 2,5 жилийн хугацаанд хийгдэх юм. Нөгөөтэйгүүр, хөрөнгө оруулагч талын нэг давуу тал бол гэрээ байгуулсны дараах өдрөөс эхлэн олборлосон нүүрсээ одоо байгаа нүүрс баяжуулах үйлдвэрээр боловсруулах боломжтой байгаа явдал юм.

Нүүрсний борлуулалтын тухайд нүүрсийг 2-оос дээш үлс уруу буюу БНХАУ болон БНСУ, Япон, Энэтхэг зэрэг нүүрс импортлогч улс орнууд уруу экспорлох үүргийг хөрөнгө оруулагч тал хүлээж байгаа;

4. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн “г”-д “Хөрөнгө оруулагч нь “Эрдэнэс-Таван толгой” ХК-иас БНХАУ-ын “Чалко” компанид төлөх өр төлбөрийн үлдэгдлийг хариуцан барагдуулж, тус компанитай байгуулсан гэрээний үүргийг хариуцах”-аар заасан.

Хөрөнгө оруулагч нь гэрээ байгуулснаас хойш 12 сар буюу нэг жилийн хугацаанд Чалко компанид төлөх 142 сая ам.долларын өрийн үлдэгдлийг холбогдох хүү болон 20 хувийн суутган татварын хамтаар төлж барагдуулах үүрэг хүлээж байгаа бөгөөд энэ зардлыг Засгийн газар болон Эрдэнэс Таван толгой ХК-иас хөрөнгө оруулагчид буцаан төлөхгүй. Хөрөнгө оруулагч нь Чалко компанид төлөх төлбөрийг гэрээний нь дагуу нүүрсээр эсхүл мөнгөн хэлбэрээр хийнэ;

5. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн “д”-д “Хөрөнгө оруулагч нь улсын төсөвт төлөх татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хариуцахаас гадна борлуулалтын орлогын тодорхой хувийг Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний төлбөрт төлөх, шаардлагатай тохиолдолд нэмж төлөх борлуулалтын орлогын тодорхой хэсгийг урьдчилан төлөхөөр хэлэлцэх”-ээр заасан.

Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсанаар хөрөнгө оруулагч тал Засгийн газарт 200 сая ам.долларын урьдчилгаа төлбөр төлөхөөр тохирлоо. Хөрөнгө оруулагчдын зүгээс 150 сая ам.долларын урьдчилгаа төлбөр өгөх санал ирсэн ч уг дүнг хэлэлцээрээр 200 сая ам. доллар гэж тохирсон болно.ийн Энэхүү урьдчилгаа төлбөрийг Эрдэнэс Таван толгой ХК-ийн санхүүгийн байдал болон улсын төсвийн орлого бүрдүүлэлтэд ачаалал үүсгэхгүйгээр Эрдэнэс Таван толгой ХК-нд төлөх түрээсийн төлбөр болон хөрөнгө оруулагчийн төлөх татвараас тодорхой хувь хэмжээгээр дараагийн жилүүдэд суутгах замаар барагдуулна.

Хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд түсгай зөвшөөрөл эзэмшигч Эрдэнэс Таван толгой ХК-тай Хамтын ажиллагааны гэрээ байгуулах бөгөөд эдгээр гэрээгээр хөрөнгө оруулагч нь Баруун болон Зүүн Цанхийн талбайтай үйл ажиллагаа явуулсны төлөө Эрдэнэс Таван Толгой ХК-д дээр түрээсийн төлбөр төлнө. Энэхүү түрээсийн төлбөрийг нүүрсний зах зээлийн үнэлгээнээс хамаарч хөрөнгө оруулагчийн тухайн хугацаанд олсон нийт борлуулалтын орлогын 2 хувиас 8 хувь хүртэл хэмжээгээр нүүрсний борлуулалтын орлогоос тооцон төлж байх юм.

Үүний дээр нэмээд төслийн компани нь Баруун болон Зүүн Цанхийн талбайтай холбоотой ногдуулах татварууд (ашигт малтмал ашигласны татвар, агаарын бохирдлын татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг)-ыг хариуцан төлөх юм.

6. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн “е”-д “Эхний ээлжинд Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг өөрийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах, ашиглалтад орсноос хойш 30 жилийн дараа 51 хувийг төрийн мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгөх үндсэн нөхцөл бүхий барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх эрхийг Концессын тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө оруулагчид олгох, Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулсны дараа коксжих нүүрсний зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Таван толгой-Сайншанд чиглэлийн төмөр замын төсөлд оролцуулах”-аар заасан.

Хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд Ухаахудаг-Гашуунсүхайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх концессын эрхтэйгээр хэрэгжүүлж, ашиглалтанд орсноос нь хойш 30 жилийн дараа 51 хувийг нь төрийн мэдэлд үнэ төлбөргүй шилжүүлэхээс гадна тухайн үед Засгийн газраас хүсэлт гаргасан тохиолдолд үлдэх 49 хувийг төлбөртэйгээр буюу уг төмөр замыг нийт 100 хувь төрийн өмчид шилжүүлэн авах үндсэн нөхцөл бүхий төмөр замын концессын гэрээ байгуулна.

Гэрээ байгуулснаар хөрөнгө оруулагч нь Монголын төмөр зам ХК-иас Ухаахудаг-Гашуунсүхайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих төслийг шилжүүлэн авах бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой өмнө гарсан зардлыг Монголын төмөр зам ХК-д холбогдох зардлын баталгаажуулалт хийсний үндсэн дээр буцаан төлнө.

7. Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын 1-ийн “ж”-д “Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний хүрээнд ордыг ашиглаж үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагч компанийн 51 хувиас багагүй хувийг Монгол Улсад нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааг 5-аас доошгүй жил эрхэлсэн түршлагатай, хувьцааных нь хяналтын багцаас доошгүй хувь нь Монгол Улсын иргэний өмчлөлд сүүлийн 5 жилийн хугацаанд байгаа хувийн хэвшлийн оператор компани болон компаниудын консерциум өмчилдөг байх”-аар заасан.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.4-т “дотоодын хөрөнгө оруулагч” гэж хөрөнгө оруулалт хийж байгаа Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн/-ийг ойлгохоор заасан байгаа. Энэ заалтын дагуу уралдаант шалгаруулалтын урилга хүлээн авсан гадаадын хөрөнгө оруулагчдын зүгээс Монгол Улсад бүртгэлтэй “Энержи Ресурс Корпораци” ХХК-ийг сонгон уг төслийг хамтран хэрэгжүүлэхээр санал ирүүлсэн нь хуулийн болон уралдаант шалгаруулалтын шаардлагыг хангаж байгаа. Тодруулбал, тус компани нь Ухаахудагийн нүүрсний уурхайд түшиглэн нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааг 2009 оноос хойш буюу 5-аас дээж жилийн хугацаанд эрхэлсэн түршлагатай байхаас гадна тус компанийн нийт хувьцааны 58 гаруй хувийг 2010 онд олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах зорилгоор Хонг Конгийн хөрөнгийн биржид бүртгүүлсэн байгаа толгой компанийн хувьцаагаар нь дамжуулан Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүд жинхэнэ хувьцаа эзэмшигчийн хувиар өмчилж байна.

Тус компаниас ирүүлсэн мэдээллээр нийт ажиллагсдын 99 хувийг (Ухаахудаг уурхайн нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа) Монгол Улсын иргэд бүрдүүлж байгаагийн 40 орчим хувийг нь Өмнөговь аймгийн иргэдээс бүрдүүлж байгаа бөгөөд ирүүлсэн танилцуулгын дагуу 2009-2014 оны туршид тус компани 35,2 сая тонн нүүрс олборлон 26,4 сая тонн нүүрсэн бүтээгдэхүүн экспортолж, 2 тэрбум гаруй ам.долларын экспортын орлогыг Монгол Улсын эдийн засагт оруулсан бөгөөд мөн хугацаанд нийт 1 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт бүхий үүл уурхайн бүтээн байгуулалтын төслийн амжилттай хэрэгжүүлэн улс, орон нутгийн төсөвт нийт 600 тэрбум гаруй төгрөгийн татвар, хураамжийн орлогыг төлсөн байна.

Хоёр. Аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулагдах бусад гэрээний талаар

Засгийн газрын түвшинд байгуулагдах Хөрөнгө оруулалтын тухай, төмөр замын концессын болон хамтран ажиллах гэрээнүүдээс гадна аж ахуйн нэгжүүдийн түвшинд

холбогдох гэрээнүүд хийгдэхээр байгаа. Эдгээр нь хэрэгжүүлж байгаа төслийн бичиг баримт, хэрэгжиж байгаа гэрээ, ажиллаж байгаа хүн хүч, техник тоног төхөөрөмжийн нэг аж ахуйн нэгжид шилжүүлэн хүлээлгэж өгөхтэй холбоотой аж ахуйн харилцаа байх юм. Тодруулбал, Таван толгойн төслийн талаар Эрдэнэс Тавантолгой ХК-тай, төмөр замын төслийн талаар “Монголын төмөр зам” ХК-тай тус тус төсөл шилжүүлэх гэрээ байгуулах юм.

Гурав. Санхүүжилтийн схем

Таван толгой ордыг хөгжүүлэх энэхүү төслийн хүрээнд жилд 30 сая тонн нүүрс олборлож, баяжуулж, тээвэрлэж, борлуулах цогц бодлогыг хэрэгжүүлэхэд эхний 5 жилийн хугацаанд нийт **4 тэрбум ам.долларын** хөрөнгө оруулалт шаардагдах урьдчилсан тооцоотой байгаа (үүнд, Ухаа худаг үүрхайг түшиглэн байгуулсан 1 тэмбум орчим ам.долларын бүтээн байгуулалт хамаарч байгаа) бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтыг дараах бүтээн байгуулалтад зарцуулах юм:

- Төмөр зам 1.16 тэрбум ам.доллар;
- Уурхайн тоног төхөөрөмж 0.64 тэрбум ам.доллар;
- Урьдчилсан хөрс хуулалт 0.71 тэрбум ам.доллар;
- Баяжуулах үйлдвэр 0.62 тэрбум ам.доллар;
- Усан хангамж 0.20 тэрбум ам.доллар;
- Эрчим хүчний хангамж 0.17 тэрбум ам.доллар;
- Барилга байгууламж 0.15 тэрбум ам.доллар;
- Бусад 0.35 тэрбум ам.доллар.

Хөрөнгө оруулагчдын зүгээс дээрх хөрөнгө оруулалтыг улсын төсөв дарамт үүсгэлгүйгээр, хөрөнгө оруулалтын эрсдлийг дангаар үүрэх байдлаар олон улсын нийтлэг жишгийн дагуу 30%-ийг нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө болон хувьцаа эзэмшигчдийн зээлээр, үлдэх 70%-г нь төслийн буюу эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэнд авах банкны шууд ба шууд бус зээлээр санхүүжүүлэх юм.

Дөрөв. Монгол Улсын эдийн засагт үзүүлэх үр өгөөж

Монгол улсын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг 3 хэсэгт хувааж тайлбарлаж болох юм.

Нэгдүгээрт, ойрын үед гарах санхүүгийн шууд үр дүн нь барагцаалбал 500-600 сая ам. доллартай тэнцэнэ. Тухайлбал, урдчилгаа төлбөр 200 сая ам.доллар, төмөр замын бүтээн байгуулалтад Монгол Улсын Засгийн газраас гаргасан хөрөнгийн эргэн төлөлт ойролцоогоор 280 сая ам. доллар, тэр нь эргээд эдийн засагт зээлийн эх үүсвэр болно. Чалко компанид төлөх байсан 142 сая ам. долларын хүндрэлээс Монгол улс чөлөөлөгдөж байгаа. Эрдэнэс Тавантолгой компанийн хөрөнгийг мөн үнэлж Консорциумд өгнө. Мөн Улсын төсөвт аливаа нэмэлт ачаалал үүсгэхгүйгээр, төслийн үйл ажиллагааны анхны өдрөөс эхлэн улс, орон нутгийн төсөвт хуулийн дагуу орлого оруулж эхлэх бөгөөд тодруулбал, холбогдох татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Цанхийн талбайд үүрхайн үйл ажиллагаа явуулсаны төлбөр зэрэгт жилд 360 орчим тэрбум төгрөг төвлөрнө.

Хоёрдугаарт, Төслийн санхүүгийн шууд бус үр дүн буюу үржүүлэгч нөлөөг барагцаалбал, ойрын 3 жилд манай ДНБ-ийг 10-аас доошгүй хувиар тэлэхээр байгаа. Уурхайн барилга байгууламж, дагалдах дэд бүтэц, ТТ-ГС чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт болон төслийн үйл ажиллагаанд дотоодын 500-600 аж ахуйн нэгжийг ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр татан оролцуулж, 8-12 мянган иргэнийг ажлын байраар хангах боломжтой болно. Төсөл бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээс хойш жил бүр Монголд дунджаар 700 сая ам. доллараас 1 тэрбум хүртэл ам. долларын үйл ажиллагааны зардал гаргах бөгөөд үүний үлэмж хэсэг нь дотоодын эдийн засагт шингэх бололцоотой.

Гуравдугаарт, Тавантолгой төсөл нь гадаадын хөрөнгө оруулагчдад эерэг мессэж болохоос гадна энэхүү төсөл нь Эгийн голын усан цахилгаан станц, Багануурын цахилгаан станц зэрэг бусад мега төслүүдэд хөтөчийн үүрэгтэй байх нь дамжиггүй юм.

Тав. Гэрээнд гарын үсэг зурах эрх олгох талаар

Төсөл банк, санхүүгийн байгууллагад хандаж хөрөнгө мөнгө босгох юм. Иймээс гэрээ болон төслийн бүхий л баримт бичигт банкны магадлан шалгалт хийгддэг нь мегатөслийн өөрийн онцлог бөгөөд эрх зүйн хувьд гарын үсэг тогтоосон хууль тогтоомжийг хангасан байх ёстой болно.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20.1-д хөрөнгө оруулалтын гэрээг Засгийн газар байгуулахаар заасны дагуу Засгийн газрыг төлөөлж “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд гарын үсэг зурах эрхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид, Монгол Улсын сайд М.Энхсайхан, нарт олгохоор тогтоолын төслийг бэлтгэсэн болно.

Харин тус гэрээний хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХК болон хөрөнгө оруулагчид, төслийн компанийн хооронд байгуулах “Хамтран ажиллах гэрээ”-нд гарын үсэг зурах эрхийг Уул уурхайн Төрийн нарийн бичгийн дарга, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох нь зүйтэй гэж үзсэн.

Тэгвэл “Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлд төмөр замын суурь бүтэц барих төсөл”-ийн барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх концессын гэрээний тухайд Концессын тухай хуулийн 6.1.2, 19.1, Төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2, 6.4, 9.1.3 дах заалтыг тус тус үндэслэн Засгийн газрыг төлөөлж Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат болон Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар нарт гарын үсэг зурах эрхийг олгох юм.

Үүнээс гадна, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1 дэх заалтын хүрээнд гадаад улсын төрийн өмчийн оролцоо бүхий БНХАУ-ын төрийн өмчлөл бүхий хөрөнгө оруулагч болох Шенхуа компанид Монгол Улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Таван толгойн нүүрсний ордыг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх төслийн компанийн нийт гаргасан хувьцааны 49 хүртэл хувийг эзэмших байдлаар Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх зөвшөөрлийг олгоно.

Зургаа. Гэрээ байгуулахтай холбоотой Засгийн газраас гарах шийдвэр болон бусад тогтоолд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар

Энэхүү хэлэлцээр амжилттай болж Засгийн газраас холбогдох гэрээнүүдийг хөрөнгө оруулагчтай байгуулахын тулд Засгийн газраас юуны өмнө “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.4.2-т заасан Ухаа худаг-Гашуунсүхайд чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих төслийг Таван толгойн ордыг хөгжүүлэх төслийн хүрээнд цогц байдлаар хэрэгжүүлэх шийдвэрийг гаргах шаардлагатай гэж үзсэн болно.

Холбогдох гэрээнүүдийг байгуулах шийдвэрээс гадна Концессын тухай хуулийн дагуу “Ухаахудаг-Гашуунсүхайд чиглэлд төмөр замын суурь бүтэц барих төсөл”-ийн барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх концессыг шууд гэрээ байгуулах замаар төмөр замын төслийг хэрэгжүүлэгч төслийн компанийн охин компани болох Энержи Ресурс Рэйл ХХК-д концессын эрх олгохын тулд юуны өмнө нь Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолын 1 дэх заалтын дагуу “Монголын Төмөр Зам” ТӨХК-д олгосон “Ухаахудаг-Гашуунсүхайд” чиглэлийн төмөр замын суурь бүтцийг “барих-ашиглах-шилжүүлэх” концессыг цуцалж, уг концессын шууд гэрээний үндсэн дээр олгох талаар Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д хавсралтад нэмэлт оруулна.

Эдгээртэй холбоотой дээр дурдсан Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолын 1 дэх заалтад ““Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасан I, II үе шатанд барих төмөр замын суурь бүтцийн” гэснийг ““Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.2 болон 3.2.4.1, 3.2.4.3, 3.2.4.4-т заасан төмөр замын суурь бүтцийг” гэж өөрчилнө. Түүнчлэн, Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолын 2 дах заалтад “энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан” гэснийг “Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.2 болон 3.2.4.1, 3.2.4.3, 3.2.4.4-т заасан” гэж, мөн тогтоолын 3 дах заалтад “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын I болон II үе шатанд барих төмөр замын суурь бүтцийг барих төслийг” гэснийг “Энэхүү тогтоолын 2-т заасан төслийг” гэж тус тус өөрчилнө. Түүнчлэн, Засгийн газрын 2013 оны 299 дүгээр тогтоолын 1 дэх заалтад “Гашуунсүхайд боомтууд” гэснийг “боомт” гэж өөрчилнө.

Улмаар Төмөр замын тээврийн тухай хуулийн дагуу төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрлийг “Энержи Ресурс Рэйл” ХХК-д олгож, өмнө нь “Монголын төмөр зам” ТӨХК-ийн эзэмшилд олгосон байсан Ухаахудаг-Гашуунсүхайд чиглэлийн төмөр замын зурвас газрыг шинэ концесс эзэмшигчийн эзэмшилд шилжүүлэх шийдвэрийг хуулийн дагуу Засгийн газар гаргана.

Мөн Ухаа худаг-Гашуунсүхайд чиглэлийн төмөр замын суурь бүтцийн төсөлтэй холбоотой гарсан зардлыг “Монголын төмөр зам” ТӨХК-д буцаан олгох зарчмаар “Ухаахудаг-Гашуунсүхайд” чиглэлийн төмөр замын суурь бүтцийн төслийг “Энержи Ресурс Рэйл” ХХК-д шилжүүлэхийг холбогдох сайд, Төрийн өмчийн хороо, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн удирдлагад үүрэг болгох юм.

Таван толгойн нүүрсний ордыг хөгжүүлэх төсөлд хөрөнгө оруулж, баруун болон зүүн Цанхийн хэсэгт хамтран ажиллах хөрөнгө оруулагчтай байгуулах Хөрөнгө оруулалтын тухай гэрээ, “Ухаахудаг-Гашуунсүхайд чиглэлд төмөр замын суурь бүтэц барих төсөл”-ийн барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ (цаашид “төмөр замын концессын гэрээ” гэх) Хамтын ажиллагааны тухай гэрээг байгуулах болон тус гэрээнүүдэд Засгийн газрын төлөөлөн гарын үсэг зурах эрхийг олгох асуудлыг уг төслийг хэрэгжүүлэхтэй

холбоотой боловсруулсан холбогдох Засгийн газрын тогтоолын төслийн хамтаар шийдвэрлэж өгөхийг хүсч байна.

---oOo---